



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 01/02

Улаанбаатар хот


Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "а", 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 8/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018-2019 онд дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулах өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.


3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын дэргэдэх Төсөв, санхүү эдийн засгийн хороо /Э.Батболд/-нд үүрэг болгосугай.



ДАРГА

Б.МӨНХЦЭЦЭГ

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны
2019 оны 08 дугаар сарын 08 -ны өдрийн
07/02 дугаар тогтоолын хавсралт



ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2018-2019 ОНД ДАМЖИН САНХҮҮЖИХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТАД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

2019.08.02

Д/д	Оруулах өөрчлөлт	Тайлбар
1	Явган хүний гүүр шинээр хийх, байршил 9 дүгээр хороо, төсөвт өртөг 9.984.400 төгрөг гэснийг Тоног төхөөрөмж худалдан авах, байршил 9 дүгээр хороо, төсөвт өртөг 9.984.400 төгрөг гэж өөрчлөх.	Гуравдугаар хавсралтын 5 дахь заалт
2	Явган хүний гүүр шинээр хийх, байршил 25 дугаар хороо, төсөвт өртөг 9.984.400 төгрөг гэснийг Иргэний танхимд тоног төхөөрөмж худалдан авах, байршил 42 дүгээр хороо, төсөвт өртөг 9.984.400 төгрөг гэж өөрчлөх.	Гуравдугаар хавсралт 7 дахь заалт